




Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 6 дугаар сарын  
11-ний өдрийн 255 дугаар тогтоолоор баталсан  
“Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4 дүгээр хавсралт маягт 2

Хагас жил, улирлын үйл ажиллагааны тайлан /маягт 2/	
<p>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</p>	
Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2024 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 3 дугаар сарын 31-ний өдөр/	2024 оны III улирал (2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 09 дугаар сарын 30-ны өдөр)
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Нэр: Ард Кредит ББСБ ХК, УБД: 9010002003, ҮЦК: ADB, Утасны дугаар: +976 77003322
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн Бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Банк бус санхүүгийн байгууллага
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	364,000,000 (Гурван зуун жаран дөрвөн сая) ширхэг
Улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: ТУЗ Нарийн бичгийн дарга Г.ЕСҮ-ҮЖИН Хянаж, баталсан: Гүйцэтгэх захирал Г.СҮХБААТАР
<p>1. Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/</p>	
Санхүүгийн байдлын үзүүлэлт	2024 оны гуравдугаар улирлын байдлаар нийт актив 90.7 тэрбум төгрөг, үүнээс цэвэр зээлийн багц 58.2 тэрбум байгаа бол нийт эздийн өмч 29.0 тэрбум төгрөг, нийт өр төлбөр 61.7 тэрбум төгрөг байна.
Орлогын тайлан	2024 оны 3-р улиралд өссөн дүнгээр хүүгийн орлого 12.7 тэрбум төгрөг, хүүгийн зардал 5.7 тэрбум төгрөг, хүүгийн бус орлого 3.0 тэрбум, бусад үйл ажиллагааны орлого 815 сая төгрөгт хүрч өссөн бол хүүгийн бус зардал 6.4 тэрбум, эрсдэлийн сангийн зардал 1.6 тэрбум, бусад үйл ажиллагааны ашиг зардал 210 сая, орлогын албан татварын зардал 367 сая төгрөг байна. Улмаар эхний хагас жилд 2.2 тэрбум төгрөгийн ашигтай ажиллав
Өмчийн өөрчлөлтийн тайлан	Тухайн улиралд хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний үнэ цэнийн бууралт 187.8 сая төгрөгөөр нэмэгдсэн, мөн 337.9 сая төгрөгөөр өөрийн хувьцааг халаасласан нь эздийн өмч буурахад нөлөөлсөн хэдий ч нөгөө талдаа улирлын дүнгээр 648.7 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллав. Улмаар эздийн өмч тайлант хугацааны эхэнд 28.7 тэрбум төгрөг байснаас 29.0 тэрбум төгрөг болж

		НЭМЭГДЭВ						
	<i>Мөнгөн гүйлгээний тайлан</i>	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 6.9 тэрбум төгрөг, эцсийн үлдэгдэл 7.3 тэрбум төгрөг байна. Тайлант хугацаанд 40.4 тэрбумын зээл олгож, 34.6 тэрбум төгрөгийн үндсэн зээлийн эргэн төлөлт хийгджээ.						
2.	<i>Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт</i>							
		Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны 2024 оны 7 сарын 05-ны өдрийн 24/02 тоот зөвлөмжөөр хагас жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, ТУЗ-өөр баталгаажуулахаар хүргүүлж, 2024 оны 7 сарын 18-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хуралд танилцуулсан.						
3.	<i>Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинэжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт</i>							
3.1.	<i>Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/</i>	<table border="1"> <tr> <td>Цэвэр ашгийн хувь</td> <td>14.3%</td> </tr> <tr> <td>Өөрийн хөрөнгийн өгөөж</td> <td>13.4%</td> </tr> <tr> <td>Нийт хөрөнгийн өгөөж</td> <td>4.0%</td> </tr> </table>	Цэвэр ашгийн хувь	14.3%	Өөрийн хөрөнгийн өгөөж	13.4%	Нийт хөрөнгийн өгөөж	4.0%
Цэвэр ашгийн хувь	14.3%							
Өөрийн хөрөнгийн өгөөж	13.4%							
Нийт хөрөнгийн өгөөж	4.0%							
3.2.	<i>Хөрвөх чадвар болон санхүүгий нөөц, боломжийн үзүүлэлт</i>	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 24.8% Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа (D/E) 1.7 Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 32.9%						
3.3.	<i>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл</i>	<p>1. Ард Кредит ББСБ ХК нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2024 оны 08 сарын 02-ны өдрийн хуралдаанаар 13,5 тэрбум төгрөгийн НЭЭЛТГЭЙ БОНД гаргах зөвшөөрөл авав. Уг бонд нь Улаанбаатар Үнэт Цаасны бирж дээр арилжаалагдаж байгаа бөгөөд андеррайтераар Апекс Капитал хамтран ажиллаж ажиллаж амжилттай 2 транч, 5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлээд байна.</p> <p>2. Харилцагчдадаа зориулан Альфа, Альфа+ зээлийг нэвтрүүлэв.</p> <p>3. Харилцагчид бусад банкны картаа Ард аппд холбосноор бүтээгдэхүүн үйлчилгээг авах, сунгалтаа татуулах боломжтой боллоо.</p>   						

3.4.	<i>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого</i>	Тухайн тайланд хугацаанд тэнцлийн гадуур зээлийн эрсдэлийн сангаас хаасан зээлийн үлдэгдэл 604.9 сая төгрөг, хүү хуримтлуулж тооцохыг зогсоосон зээлийн үлдэгдэл 429.5 сая төгрөг байна.																													
4.	<i>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</i>																														
<p>Их хэмжээний хэлцэл: Тайлант хугацаанд их хэмжээний хэлцэл хийгдээгүй болно. Сонирхлын зөрчилтэй хэлцэл. 2024 оны 3-р улиралд:</p> <ol style="list-style-type: none"> <li>Өндөрхаан ХК-д 1,000,000,000.00 төгрөгийг 12 сарын хугацаатай авлага үүсгэн шилжүүлэв. Огноо: 2024.07.05</li> <li>Ард Секюритиз ҮЦК ХХК-тай байгуулсан зээлийн гэрээний хугацааг 6 сараар сунгаж, 600,000,000.00 төгрөгийн авлага үүсгэж шилжүүлэв. Огноо: 2024.07.30</li> <li>Ард Секюритиз ҮЦК ХХК-д 2,000,000,000.00 төгрөгийг 2 сарын хугацаатай авлага үүсгэн шилжүүлэв. Огноо: 2024.07.30</li> <li>Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн зээлийн гэрээний хугацааг 12 сараар сунгаж, зээлийн эргэн төлөлтийг хагас жилд нэг удаа болгон өөрчлөв. Огноо: 2024.09.30</li> <li>Ард Секюритиз ҮЦК ХХК-д 700,000,000.00 төгрөгийг 3 сарын хугацаатай авлага үүсгэн шилжүүлэв. Огноо: 2024.09.30</li> <li>Ард Лизинг ХХК LA-740-BMW-740 LI маркын машин 333,076,809.25 төгрөгөөр худалдан авах, Mitsubishi Fuso маркын машин 256,666,666.67 төгрөгөөр худалдан авах тухайн гэрээ байгуулав. Огноо: 2024.09.30</li> </ol>																															
5.	<i>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл</i>																														
<p>Ард Кредит ББСБ ХК нь 2024 оны 3 сарын 01-ний өдрөөс 2024 оны 09 сарын 30 хүртэлх хугацаанд ГРО татан төвлөрүүлсэн хөрөнгийн 73.4% буюу (30.0 хувь буюу нийт 2.4 тэрбум төгрөгийг хөрөнгө барьцаалсан зээлд, 20.0% буюу 1.6 тэрбум төгрөгийг хэрэглээний онлайн зээлд, 23.4% буюу 2.2 тэрбум төгрөгийг бичил, жижиг дунд бизнесийн зээлд) нийт 6.2 тэрбум төгрөгийг төлөвлөгөөний дагуу зарцуулаад байна. Үлдэгдэл 1.9 тэрбум төгрөгөөс тодорхой хувийг шугамын зээлийн эргэн төлөлтөд хийж үлдэгдэл мөнгийг харилцах дансанд хадгалж байна.</p> <table border="1" data-bbox="276 1554 1501 1832"> <thead> <tr> <th rowspan="2">Ангилал</th> <th colspan="2">Зарцуулалтын төлөвлөгөө</th> <th colspan="2">Зарцуулалтын гүйцэтгэл</th> </tr> <tr> <th>Үнийн дүн /₮ сая/</th> <th>Хувь</th> <th>Үнийн дүн /₮ сая/</th> <th>Хувь</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Хөрөнгө барьцаалсан зээл</td> <td>2,440.2</td> <td>30.0%</td> <td>2,440.2</td> <td>30.0%</td> </tr> <tr> <td>Хэрэглээний зээл</td> <td>1,626.8</td> <td>20.0%</td> <td>1,626.8</td> <td>20.0%</td> </tr> <tr> <td>Бичил жижиг дунд бизнесийн зээл</td> <td>4,066.9</td> <td>50.0%</td> <td>2,168.3</td> <td>26.7%</td> </tr> <tr> <td>Нийт</td> <td>8,133.9</td> <td>100.0%</td> <td>6,235.2</td> <td>76.7%</td> </tr> </tbody> </table>			Ангилал	Зарцуулалтын төлөвлөгөө		Зарцуулалтын гүйцэтгэл		Үнийн дүн /₮ сая/	Хувь	Үнийн дүн /₮ сая/	Хувь	Хөрөнгө барьцаалсан зээл	2,440.2	30.0%	2,440.2	30.0%	Хэрэглээний зээл	1,626.8	20.0%	1,626.8	20.0%	Бичил жижиг дунд бизнесийн зээл	4,066.9	50.0%	2,168.3	26.7%	Нийт	8,133.9	100.0%	6,235.2	76.7%
Ангилал	Зарцуулалтын төлөвлөгөө			Зарцуулалтын гүйцэтгэл																											
	Үнийн дүн /₮ сая/	Хувь	Үнийн дүн /₮ сая/	Хувь																											
Хөрөнгө барьцаалсан зээл	2,440.2	30.0%	2,440.2	30.0%																											
Хэрэглээний зээл	1,626.8	20.0%	1,626.8	20.0%																											
Бичил жижиг дунд бизнесийн зээл	4,066.9	50.0%	2,168.3	26.7%																											
Нийт	8,133.9	100.0%	6,235.2	76.7%																											
6.	<i>Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл</i>																														
<ul style="list-style-type: none"> <li>Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 2024/39 тогтоолоор Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны даргаар хараат бус гишүүн Б.Солонгыг томилов.</li> <li>Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 2024/40 тогтоолоор ТУЗҮАЖ, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны журамд өөрчлөлт оруулан шинэчлэн батлав.</li> </ul>																															

	<ul style="list-style-type: none"> <li>Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 2024/42 тогтоолоор сургалтын төлөвлөгөөг баталсан бөгөөд тогтоолын хэрэгжилтийг хангуулан ТУЗ-ийн сургалт болон ритрийг 2024 оны 09 сарын 26-ны өдөр болж өнгөрлөө.</li> <li>Ард Кредит ББСБ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2024 оны 08 сарын 29-ний өдөр амжилттай зохион байгуулагдлаа.</li> </ul>
7.	<i>Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл</i>
	<p>2024 оны III улирлын байдлаар дараах тайлан мэдээллүүдийг холбогдох хууль, тогтоомжид заасан хугацаанд илгээж, олон нийтэд мэдээлсэн байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>2024 оны II улирлын Мастер тайлан;</li> <li>2024 оны 2 дугаар улирлын санхүү, үйл ажиллагааны тайлан;</li> <li>Комплаенсын эрсдэлийн үнэлгээний тайлан;</li> <li>2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын материал болон шийдвэр;</li> <li>Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоол;</li> </ul>
Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:	
Овог, нэр: Г.Сүхбаатар	
Албан тушаал: Ард Кредит ББСБ ХК-ийн Гүйцэтгэх захирал	
Гарын үсэг: .....	
Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:	
Овог, нэр: Г.Есү-Үжин	
Албан тушаал: ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга	
Гарын үсэг: .....	